



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 158

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Сумын төрийн албан хаагчдын орчин нөхцөлийг сайжруулах” арга хэмжээний хүрээнд хийгдэх “Тавилга ширээ сандал худалдан авах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн:

Н.Амаржаргал

(Мэдээлэл технологи, олон нийттэй харилцах ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Арга хэмжээний хүрээнд хийгдэх “Өрөөний тавилга худалдан авах ажил”-ыг шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу тавилга хэрэгслийг хүлээн авч, тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

